



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/216

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5.9, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар Сумын өвсний фондод тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг “Хутагт-Уулын Өгөөж” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулсугай.

2. “Хутагт-Уулын Өгөөж” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Сумын өвсний фондод тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын 3,000,000 (гурван сая) төгрөгийн санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын бусад хөрөнгө зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

